

Сургууль дээрх сурагчийн гар утасны хэрэглээ

Эцэг эх/асран хамгаалагчид зориулсан мэдээлэл

Ахлах сургуулиудад гар утас хэрэглэхийг хориглосон заалт хэрэгжиж эхэлсэн болно

NSW-ийн улсын бага сургуулиудад аль хэдийн хэрэгжиж эхэлсэн хориг дээр тулгуурлан ахлах сургуулиудад гар утас ашиглахыг хориглож байгаа болно.

Хичээл, завсарлага, үдийн хоолны үеэр уг хориг хүчинтэй байх болно. Сурагчид сургуульд ирэх, сургуулиас явах үедээ утас авч явахыг зөвшөөрнө.

Захирал болон багш нар боловсролын зорилгоор эсвэл сурагчийн сурч боловсрох, сайн сайхан байдалд тохирсон зохицуулалтын нэг хэсэг болгон гар утас ашиглахыг зөвшөөрч болно.

Уг хоригийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхийн тулд NSW-ийн Боловсролын яамнаас хоригийг хэрэгжүүлэх хувилбарын талаар орон нутгийн ард иргэд байгууллагуудтай зөвлөлдөхийг сургуулиудад зөвлөсөн болно.

Дараах хувилбарууд байх боломжтой:

Утсыг унтрааж хол байлгах: Утсыг унтраан хол байлгана (ихэвчлэн сурагчийн цүнхэнд). Хичээлийн өдрийн турш сурагч утас ашиглахгүй байна.

Утсыг шүүгээнд хадгалах: Сурагчид утсаа биедээ авч явахгүй байна. Хичээлийн өдрийн турш утас шүүгээнд хадгалагдах ёстой.

Түгжээ бүхий утасны уут: Сурагчид утсаа соронзон цоожтой уутанд хийх ба хичээлийн цагаар утсаа ашиглах боломжгүй байна. Хичээлийн төгсгөлд уутны түгжээ нь соронзон аргаар тайлагдах болно.

Сургуулийн оффис дээр утсыг хүлээлгэн өгөх: Сурагчид хичээлийн өдөр эхлэхэд утсаа сургуулийн оффист өгч, хичээлийн өдрийн төгсгөлд (эсвэл сургуулийн байрнаас гарахдаа) авна.

Хичээлийн эхэнд утсыг цуглуулах: Хичээл эхлэхэд багш утсыг цуглуулж хадгалах бөгөөд хичээл дуусмагц болон/эсвэл сурагчийг ангиас гарах үед/ сурагчид буцааж өгнө.

Тус бодлогыг хэрэгжүүлэхийн тулд аль хувилбарыг хэрэгжүүлэхийг тухайн сургуулийн хамт олон шийдсэн.

Хичээлийн цагаар сурагчид эцэг эх, асран хамгаалагчтайгаа харилцах нь

Эцэг эх, асран хамгаалагчид сурагчтай сургуульд байх үед нь холбоо барих, эсвэл эсрэгээр сурагч эцэг эх, асран хамгаалагчтайгаа холбогдох шаардлага гарах үе гарч болно. Эцэг эх, асран хамгаалагчид сургуулийн оффисоор дамжуулан сургуультай холбогдох боломжтой. Сурагч яаралтай тохиолдолд сургуулийн оффисоор дамжуулан эцэг эх, асран хамгаалагчтайгаа холбогдох боломжтой.

Утсан орчуулгын үйлчилгээ

Хэрэв та нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл сургууль руу залгана уу. Хэрэв танд орчуулагч хэрэгтэй бол Утсан орчуулгын үйлчилгээний 131 450 утсаар холбогдон өөрийн хэлээр орчуулагч авна уу.

Операторт залгахыг хүсч буй утасны дугаараа хэлбэл оператор шугаман дээр орчуулагчийг оруулан ирж танд туслах болно. Энэхүү үйлчилгээ үнэ төлбөргүй.

